



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20¹⁶ он⁰⁴ дугаар
сарын¹⁸ны өдөр

Дугаар^{хэг/719}

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.БОЛДБААТАР ТАНАА

Мэдээлэл хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газраас нийгмийн даатгал, халамж, тэтгэвэр, тэтгэмж, ядуурал, ажилгүйдэл, эрүүл мэнд, боловсрол, орон нутгийн хөгжлийг дэмжих, хөдөө, аж ахуй, аж үйлдвэр, жижиг, дунд үйлдвэрлэл, дэд бүтэц, байгаль орчны чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх товч мэдээллийг 2016 оны эхний улирлын байдлаар гарган хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт 45 хуудас.

Дэд дарга

A rectangular official seal of the Mongolian Parliament, featuring a decorative border and the name of the assembly in both Mongolian script and Latin characters.

Г.ГАНБОЛД

ЗУРГАА. ХӨДӨӨ АЖ АХҮЙН САЛБАРТ ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

1. Эрх зүйн орчинг боловсронгуй болгох хүрээнд

Хууль:

- Тариалангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг УИХ-ын чуулганы 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн батлав.
- Органик хүнсний тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганы 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн батлав.
- Газар тариалангийн тоног төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн нэгдсэн чуулганаар хэлэлцэн батлав. Хууль батлагдсантай холбоотой Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж байна.
- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах, Байнгын хороо, Нэгдсэн чуулганы хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хэсэг, дэд хэсэг хуралдаж, зарчмын зөрүүтэй саналыг эцэслэв. УИХ-ын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос Дэд ажлын хэсгийн хуралдааныг 2016 оны 03 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулав.
- Малын генетик нөөцийн тухай хуулийн төслийг УИХ-ын чуулганаар “хэлэлцэх эсэх”-ийг хэлэлцэн дэмжсэн. Хуулийн төслийг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлтгэх дэд ажлын хэсэг БОХХАА-н Байнгын хорооны тогтоолоор байгуулагдан ажиллаж байна.

УИХ, Засгийн газрын тогтоол, сайдын тушаал:

- “Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортжуулах богино хугацааны хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2016 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаар батлав.
- “Халх гол” төслийн хэрэгжилтийн талаарх танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл бэлтгэн 2016 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 01/454 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв. Засгийн газрын 2016 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн тэмдэглэл гаргав.
- Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх газар тариалангийн тоног төхөөрөмжийн жагсаалтыг Засгийн газрын 2016 оны 4 дүгээр сарын 04-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлав.
- “Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх инновацийн хөтөлбөр”-ийг Сайдын 2016 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А-43 дугаар тушаалаар батлуулав.

Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 4-ний 90 тоот тогтоолоор Төрийн банкинд үүрэг болгосны дагуу 40.7 тэрбум төгрөгийн дүн бүхий 17411 малчин зээлдэгчийн хүүг 18 хувь буюу сарын 2.5 хувиас 1.5 хувь болгон бууруулсан. Засгийн газрын 2016 оны 2 дугаар сарын 22 өдрийн 113 болон 114 тоот тогтоолоор “Сайн малчин хөтөлбөр”-ийг “Мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжих дэд хөтөлбөр”-ийн хамт баталсан. Үүний дагуу Төрийн банкнаас 10 хувийн хүүтэй малчны зээлийг ямар шалгуур, шаардлага хангасан малчдад олгох талаар зарчим, схемүүд батлагдсан. Дэд хөтөлбөрөөр баталсан шалгуур үзүүлтийг хангасан малчид өмнө нь авсан 18 хувийн хүүтэй зээлээ хаагаад шинээр 10 хувийн хүүтэй зээл авах боломж бүрдлээ. Малчин өрхийн хувьд 10 хувийн хүүтэй зээлд хамрагдахын тулд дараах гурван шалгуурыг хангасан байх ёстай.

Үүнд:

1. Малаа тогтмол хугацаандаа вакцин, туулга, ариутгалд хамруулдаг байх
2. Эрүүл мэнд, Нийгмийн даатгал тогтмол төлдөг байх
3. Арилжааны банкинд Малчин данстай байх ёстай.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХҮЙН САЛБАРЫН ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИ, ИННОВАЦИИ ҮНДЭСНИЙ ЧУУЛГАНЫГ 2016 оны 03 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулав. Үндэсний

чуулганы хүрээнд нэгдсэн хуралдаан, инновацийн бүтээгдэхүүний үзэсгэлэн зохион байгуулагдаж уг арга хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль, хувийн хэвшилийн нийт 260 гаруй төлөөлөл оролцов. Инновацийн бүтээгдэхүүний үзэсгэлэнд нийт 30 гаруй аж ахуйн нэгж, эрдэм шинжилгээний байгууллага, их дээд сургууль, гарааны компанийн төлөөлөл оролцож судалгаа, туршилтын ажлын үр дүнгээр бий болсон бүтээгдэхүүнүүдээ танилцуулав. Мөн түүнчлэн тус салбарт сүүлийн 10 жилийн хугацаанд бий болсон инновацийн бүтээгдэхүүний 500 гаруй дээжис орсон ИННОВАЦИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЭМХЭТГЭЛ-г хэвлэн гаргаж чуулганы төлөөлөгчдөд хүргүүлэв.

ТЭРГҮҮНИЙ МАЛЧДЫН УЛСЫН ЗӨВЛӨГӨӨН-ийг 21 аймгийн 330 сумын 700 малчин, мэргэжилтнүүд, их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, холбогдох төрийн байгууллагын төлөөлөл нийт 900 хүнийг оролцуулан Улаанбаатар хотод зохион байгуулав.

“МОНГОЛ ТЭМЭЭ 999” уралдаан, тэмээчдийн зөвлөгөөнийг 11 аймгийн 30 сумын төлөөлөл 1600 тэмээтэй 2000 гаруй тэмээчдийг оролцуулан 03 дугаар сарын 6, 7-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Даланзадгад суманд зохион байгуулав. Энэ уралдаанд 1115 тэмээ уралдсанаас 1108 тэмээ барианы зурхайд баригдсанаар дэлхийн дээд амжилтыг тогтоон Гиннесийн номонд бүртгүүлэв.

Малын эмийн салбар зөвлөлийн ээлжит хуралдааныг 2016 оны 01 дүгээр сард зохион байгуулж 4 улсын 9 эмийн үйлдвэрт үйлдвэрлэсэн 22 нэр төрлийн малын эм, түүхий эдийн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэв.

Хүнсний болон үрийн улаанбуудай импортлох үйл ажиллагааг нэг цонхны бодлогоор зохион байгуулан ажилласан ба үрийн улаанбуудай импортлох зөвшөөрлийг 27 аж ахуйн нэгжид 14423 тонн үрийн улаанбуудай импортлох зөвшөөрөл олгосноос ГЕГ-аас ирүүлсэн мэдээгээр импорт хийгдээгүй, хүнсний улаанбуудай 125000 тонн импортлох зөвшөөрлийг нийт 25 аж ахуйн нэгжид олгосноос ГЕГ-аас ирүүлсэн мэдээгээр 68928 тонн хүнсний улаанбуудай импортлогдоод байна.

Улсын хэмжээнд 2016 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт эх малын 24.3% буюу 5543.8 мянган эх мал төллөж, 5424.4 мянган төл хүлээн аваад байна. Үүнээс: 20.3 мянган унага, 20.2 мянган ботго, 101.3 мянган тугал, 2754.1 мянган хурга, 2528.5 мянган ишиг бойжуулж төл бойжилт 97.8 хувьтай байна.

НҮБ-ын санхүүжилтээр Зудын эрсдэлийг бууруулах яаралтай тусlamжийн 1,3 сая ам.долларын төслийг хэрэгжүүлж эхлэв.

Хөдөө аж ахуйн биржийн арилжааг орон нутгаас анх удаа амжилттай зохион байгууллаа. Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд (туршилтаар) анх удаа Өмнөговь аймгийн Даланзадгад сумын “Хотол таван эрдэнэ” хоршоо оролцож, 900 кг буюу 9 богц үргэлж, цагаан, боловсруулаагүй хонины ноосыг захиалганд орууллаа.

“Max” хөтөлбөрийн хүрээнд зээлийн дэмжлэг үзүүлэх сонгон шалгаруулалтад 37 аж ахуйн нэгж материал ирүүлснийг ажлын хэсэг үнэлж, 26 аж ахуйн нэгжийг шалгаруулж, MX16/02/25 тоот урилгын дагуу Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын хаврын улирлын хэрэгцээнд зориулан тогтвортой үнээр max нийлүүлэх сонгон шалгаруулалтын шаардлагад нийцсэн аж ахуйн нэгжийн жагсаалтыг Монгол Улсын Хөгжлийн банк болон хөтөлбөрт оролцогч арилжааны банк, аж ахуйн нэгжид хүргүүлж ажилласан.

ЕС. БАЙГАЛЬ ОРЧНЫ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ

Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого, эрх зүйн орчныг сайжруулах хүрээнд:

- Монгол Улсын Их Хурлын 2014 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан “Ногоон хөгжлийн бодлого”-ыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж батлуулав.
- Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалтад авах 7 газрыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтоолын төслийг боловсруулж, холбогдох материал болон хавсралтыг 2016.03.02 01/1068 тоотоор Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлэв. Үүнд: Говийн их дархан цаазат газар“Б”хэсгийн өргөтгэл Булган гол-Их Онгогийн БЦГ-ын өргөтгэл, Дарьгангын БЦГ-ын өргөтгэл, Отгонтэнгэрийн ДЦГ-ын өргөтгэл Дулаан хайрхан уул, Дэлгэрхаан уул, Цагаан дэлийн агуй зэрэг болно.
- ЗГ-ын хуралдаанаар химиин хорт болон аюултай бодисыг импортлох, хил дамжуулан тээвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход төлдөг төлбөрийн хэмжээг тогтоодог “Улсын тэмдэгтийн хураамж”-ийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлж дэмжүүллээ. Уг хуулийн төсөлд химиин хорт болон аюултай бодис импортлох, хил дамжуулан тээвэрлэх тусгай зөвшөөрөл олгоход төлөх тэмдэгтийн хураамжийн дээд доод хязгаарыг өөрчлөн “60000-20000000 төгрөг” болгох санал тусгагдлаа. Орон нутагт 2 ойн анги нэмж байгуулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар бэлтгэн оруулж 2016 оны 2 дугаар сарын 1-ний өдрийн 79 дугаар тогтоолоор батлуулав.
- Засгийн газрын 2016 оны 02 дугаар сарын 29-ны өдрийн 12 дугаар ээлжит хуралдаанд “Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн үзэл баримтлалыг хэлэлцүүлж, батлуулав.
- Озон задалдаг бодис болон бусад орлуулах бодис, тэдгээрийг агуулсан тоног төхөөрөмж импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох журмыг шинэчлэн батлах тухай журмын төслийг боловсруулав.
- 2013 онд Бурхан Халдун уулыг Дэлхийн өвд бүртгүүллээ. Энэ нь Бурхан Халдун уулын үнэ цэнийг дэлхий дахинд хүлээн зөвшөөрүүлсэн явдал юм.

Бодлогын хэрэгжилтийг хангах хүрээнд:

БОНХАЖ-ЫН Сайд болон Нийслэлийн Засаг дарга нар “Туул усан цогцолбор” байгуулах асуудлаар хамтран ажиллахаар 2015.04.20-ны өдөр гарын үсэг зурсан. “Хамтран ажиллах санамж бичиг”-ийн дагуу “Туул усан цогцолбор” төслийн ТЭЗҮ болон техникийн зураг төслийг боловсруулах ажлыг Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газартай хамтран, зөвлөх компаниар БНСУ-ЫН “Ю Шин” компанийг ажиллуулж байна. Тус төслийн ТЭЗҮ-ийг мэргэжилтнүүдийн хүрээнд 2 удаа хэлэлцүүлэг хийгдлээ.

Эгийн гол дээр усан цахилгаан станцын далан, усны барилга байгууламж баригдах газар болон усан толио үүсэх газрыг үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт хэрэгжүүлэх газрын зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авахаар ЗГ-ын тогтоолын төслийг боловсрууллаа.

Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл”-ийн хүрээнд Умард говийн гувээт-Халхын дундад талын сав газар, Алтай өвөр говийн сав газар, Галба-Өвөш-Долоодын говийн сав газрын нутаг дэвсгэрт газрын доорх усны хяналт-шинжилгээний зориулалтаар 119 цооногт сууринуулсан автомат болон хагас автомат багаж тоног төхөөрөмжийг нэгдсэн сүлжээнд холбох ажлыг гүйцэтгэж байна.

Мөн тус төслийн хүрээнд Дундговь аймагт “Говийн бүсэд ул хөрсний усны чанарын суурь судалгаа”-ны төслийг хэрэгжүүлж төгсгөлийн тайланг Дэлхийн банкинд хүлээлгэн өглөө.

“Улаанбаатар хотын гэр хорооллын хөрсний бохирдлын мөнежмент” төслийн саналыг бэлтгэн Азийн хөгжлийн банкны дэмжлэг авч 2.7 сая ам.долларын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх баримт бичигт 2015 оны 09 дүгээр сарын 17-нд гарын үсэг зуран баталгаажуулж, төслийн дизайн боловсруулах ажлыг эхлүүлсэн.

Салбарын Сайд Н.Батцэрэг Испаний Вант Улсын Мадрид хотноо байрлах Нэгдсэн үндэстний байгууллагын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын төвд ажлын айлчлал хийлээ. Энэхүү айлчлалын үеэр ДАЖБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Талеб Рифаи болон албаны бусад хүмүүстэй уулзаж, Аялал жуулчлалын тандалт, судалгааны төвийг /Tourism observatory/ Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын тусlamжтайгаар анх удаа байгуулах, "Нүүдэлчдийн аялал жуулчлал, хотуудын тогтвортой хөгжлийн Торгоны замын хуралдаан" (англиар Silk Road Conference on Nomadic Tourism and Sustainable Cities) сэдэвт Олон улсын аялал жуулчлалын анхдугаар хуралдааныг 2016 оны 10 дугаар сард Улаанбаатар хотноо Дэлхийн аялал жуулчлалын байгууллагатай хамтран зохион байгуулах, НҮБ-ын Дэлхийн аялал жуулчлалын байгууллагын төвд Монгол Улсаас мэргэжилтнүүдийг урт хугацаанд дадлагажуулан ажиллуулах, тус байгууллагаас зохион байгуулдаг сургалтад мэргэжилтнүүдээ хамруулах, Аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчныг сайжруулж, аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн төлөвлөгөөг боловсруулах, олон улсын төлөвлөгөөтэй уялдуулахад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, Торгоны замын аялал жуулчлалын хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлэх тал дээр техникийн тусlamж авахаар тохиролцов.

БОНХАЖЯ-ны урилгаар 03 дугаар сарын 26-ны өдөр гурван улсад ээлжлэн зохион байгууллагддаг "Монгол, Орос, Хятад гурван улсын таван хотын аялал жуулчлалыг зохицуулах хурал"-ыг Монгол Улсын Нийслэлийн аялал жуулчлалын газар, БНХАУ-ын ӨМӨЗО-ны Аялал жуулчлалын товчоо, ОХУ-ын Өвөр Байгаль хязгаарын олон улсын хамтын ажиллагаа, гадаад эдийн засгийн харилцаа, аялал жуулчлалын яам, ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын Аялал жуулчлалын товчоо, ОХУ-ын Эрхүү мужийн Аялал жуулчлалын газар хамтран гурав дахь удаагаа Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Хурлаар талууд 2015 оны хурлын протоколын хэрэгжилтийг дүгнэж, цаашдын хамтран ажиллах зорилго болон тодорхой саналыг судалж, асуудлуудыг хэлэлцэж тохиролцсон бөгөөд Монгол Улс, Оросын Холбооны Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын таван мужийн аялал жуулчлалын зөвлөлдөх хурлын 2016 оны протоколд гарын үсэг зурлаа.

Агаарын чанарыг сайжруулах III бүсэд орших ХУД-ийн 10 мянган айл өрхийн хэрэглэж буй түүхий нүүрсийг нүүрс цэвэршүүлэгч бодисоор баяжуулан турших ажлыг 2016 оны 1 дүгээр сарын 15-аас эхлүүлсэн бөгөөд 3 дугаар сарын сарын 16-ны өдөр бүх хороонд 10000 ширхэгийг тарааж дуусгав.